



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮД ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 ОН



АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

- Компанийн түүхэн товчоо
- Эрхэм зорилго, Үнэт зүйл

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

- 2021 оны зорилт, гүйцэтгэл

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Бизнесийн стратеги
- Зах зээлийн хувь хэмжээ

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Хүний нөөцийн бодлого
- Нийгмийн хариуцлага

ОЛОЛТ АМЖИЛТ

2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ





ТАЛХ ЧИХЭР ХК



ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЬ СОНГОЛТ
ОНООС

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



What?!

КОМПАНИЙН ТҮҮХ



1984-1999 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ОН ЖИЛҮҮД

1984 он - "Талх чихрийн комбинат" нэртэйгээр ашиглалтад оруулж, хоногт 90тн талх, 5000тн чихэр, жигнэмэг, Өрмөнцөр, 6550тн бялуу, 800тн жимсний чанамал гэх мэт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхлэв.

1999-2004 ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТИЙН ОН ЖИЛҮҮД

1999 он - "Талх Чихэр" ХК болон хувьчлагдав.
2003 он - БНСУ-ын Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх хөргүүртэй болон хөргүүргүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, Тайван улсын сахарын болон хатуу төрлийн жигнэмэгийн шугам ашиглалтад оруулав.
2004 он - Микробиологи, Химийн лабораторид шинэчлэл хийж, дугуй талх үйлдвэрлэх компьютерийн удирдлагатай иж бүрэн шугам ашиглалтад оров.

2006-2014 ИНОВАЦИ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОН ЖИЛҮҮД

2006 он - Монгол Улсдаа анх удаа зүссэн талхны хэрэглээг хэрэглэгчдэд нэвтрүүлж, хэрэглээний соёл түгээв.
2008 он - Гурил шуудайгүйгээр тээвэрлэх тоног төхөөрөмжийг Герман, Украин улсад захиалж, хийлгэв.
2010 он - Нарийн боовны үйлдвэрлэлийн техник технологийг БНЧУ, Голланд улсын иж бүрэн тоног төхөөрөмжөөр шинэчлэв.
- "Та Чи", "Органик" брэндийн зохицуулах үйлчилгээтэй нарийн боов шинээр худалдаанд гаргаж, эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүний хэрэглээний соёлыг түгээв.
2012 он - "Та Чи" 4 төрлийн баяжуулсан талхны урсгал шугам суурилуулав.
2013 он - Улсдаа анх удаа бүрэн автомат талх савлагч төхөөрөмж суурилуулав.
- Дархан, Эрдэнэт хотуудад борлуулалтын баг ажиллуулж, анхны түгээлтээ эхлүүлэв.
2014 он - Чаналгын бүтээгдэхүүний тос шүүгч бүрэн автомат урсгал шугамыг Итали улсын CEPI, CANOL, TECHNO-D ЧЕХ улсын TOPOS фирмүүдэд захиалж, Монгол Улсдаа анх удаа суурилуулав.

2014-ОНООС ХЭРЭГЛЭЭНИЙ СОЁЛЫГ ТҮГЭЭЖ, ХЭРЭГЛЭГЧДИЙН ХАНДЛАГЫГ ӨӨРЧЛӨХ ОН ЖИЛҮҮД

2014 он - "Фрэнч багет" брэндийг үйлдвэрлэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгон нэвтрүүлэв.
2015 он - Орос технологийн Бородино, сэндвич, бургерийн талхыг үйлдвэрлэж, худалдаанд нэвтрүүлэв.
- Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2008 олон улсын стандартыг салбартаа анх удаа нэвтрүүлэв.
2016 он - Талх, нарийн боовны үйлдвэрт тус бүр 30.000м2 бүрэн автомат агааржуулалтын системийг суурилуулав.
2017 он - Ази тивд анх удаа БНЧУ-ын J4 компанийн хоёр давхар пийшинтэй талхны иж бүрэн урсгал шугам ашиглалтад оруулж, Итали улсын CEPI компаниас 500тн гурил вакуум орчинд хадгалах, дамжуулах зориулалт бүхий иж бүрэн системийг угсарч суурилуулав.
- Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны ISO 22000:2005 олон улсын стандартыг салбартаа анх удаа нэвтрүүлэв.
2018 он - Талх 30 нэр төрөл, нарийн боов 35 нэр төрөл, бялуу болон бэйкери 60 нэр төрөл, жигнэмэг 10 гаруй нэр төрлийг тус тус үйлдвэрлэж,
- Итали улсын CEPI компаниас 500тн гурил вакуум орчинд хадгалах, дамжуулах зориулалт бүхий иж бүрэн системийг угсарч суурилуулав.
- Онцгой брэндийн 6 нэр төрөл бүхий бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, ХХААХҮЯ-ны "Шинэ нэр төрлийн шилдэг бүтээгдэхүүний шагнал"-ын эзэн болов.
2019 он - "Талх чихэр" ХК 35 жилийн босгон дээрээ "Та чи" бэйкери "Хотол" бялууны үйлдвэрийн нээлтээ хийж, 100 гаруй нэр төрлийн бялуу, бэйкери бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэв.
- "Ухаалаг хэрэглэгч" хөтөлбөр хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй, ухаалаг хэрэглээг дэмжин, хэрэглэгчдэд хэвшүүлж эхлэв.
2020 он - "Martin's Bread" брэндийн талхыг худалдаанд гаргаж эхлэв.
- Орчин үеийн хэрэглэгчдийн чиг хандлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор "Талх Чихэр" ХК болон "Мах Импекс" ХК хамтран "Дэлхийн брэндийг дурсаараа бүтээе" уриатай "Хаан" брэндийн бургер, хотдогны талхыг зах зээлд нэвтрүүлээ.
2021 он - Залуу гэр бүлүүдэд зориулан "Түмэн насан" брэндийн "Өв соёл" хэвийн боовыг зах зээлд нэвтрүүлэв. Энэхүү бүтээгдэхүүн нь өрх тусгаарлаж, гал голомтоо бадраасан залуу гэр бүлүүдэд зориулагдсан. Мөн "Ковид-19"-ийн үед Монголын үндэсний уламжлалт баяр болох "Цагаан сар"-ын баяраар айл хотлоор зочлохгүйгээр ам бүлээрээ гэр гэртээ өв соёлоо дээдлэн, жижиг ч гэсэн тавгийн идээ засах хэрэгтэй гэсэн соёлыг хэрэглэгчдэд хүргэж чадсан.
- "Хотол" бялууны үйлдвэрээ өргөжүүлэх хүрээнд "Хубилай" нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, ХОТОН Бялууг дотоодод өрсөлдөгч шилдэг бүтээгдэхүүн болгох эхлэлийг бид тавьсан.
- Хүүхэд багачуудад зориулан зөөлөн, амтлаг, бутрамттай, өөг бүтээгдэхүүн болох "Амтлаг" брэндийг зах зээлд амжилттай нэвтрүүлээ.



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮД ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС

03

ҮНЭТ ЗҮЙЛС

Т - Тэргүүн технологи

А - Аюулгүй бүтээгдэхүүн

Ч - Чадварлаг ажилтан

И - Итгэлцэл, түншлэл

01

Эрхэм зорилго

Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.

02


Алсын хараа

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

КОМПАНИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НӨӨЦ



Нийт ажилтан
886



Нийт ажилтны 70% орчим нь
25-40 хүртлэх насны
залуучууд эзлэж байна.



ТАЛХ ЧИХЭР ЖК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНН СОНГОЛТ
ОНООС

КОМПАНИЙН ҮЙЛЭЖИЛЛЭГЭЭНИЙ ТОЙМ



What?!

2021 оны үйл ажиллагааны тойм

2021 онд **886** ажилтантайгаар **150 гаруй** нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажилласан байна.

Хэдий COVID-19 цар тахлын үе таарсан хэдий ч бид ажилчид болон тэдний ар гэрийнхэнд зориулсан нийгмийн халамжийн үйл ажиллагааг үе шаттайгаар хийж хэрэгжүүлж, ажилчдаа 90 гаруй хувийг вакцинжуулалтад хамруулж, эрүүл мэндийг нь учир ч болох эрсдэлээс хамгаалах тал дээр онцгой анхаарч байна.

Зах зээл болон хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж, шинэ хэрэглээ, соёл бий болж байгаатай холбогдуулан үндэсний уламжлалт “Цагаан сар”-ын баяраар залуу гэр бүлд зориулсан “Өв соёл” хэвийн боовыг үйлдвэрлэн, онцгой дэглэмтэй онцгой үед айл хотлоор зочлохгүйгээр ам бүлээрээ гэр гэртээ өв соёлоо дээдлэн, жижиг гэсэн тавгийн идээ засах уламжлалаа хадгалж, эрхэмлэх соёлыг хэрэглэгчдэд хүргэж чадсан.

Мөн “Хотол” бялууны үйлдвэрийн үйл ажиллагаанд онцгойлон анхаарч, “Хубилай” төслийн хүрээнд БЯЛУУ гэх амттан хаанаас үүссэн тухай түүхийг өгүүлсэн богино хэмжээний баримтат киног бүтээж, шинэ мэдлэг мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж чадсан байна.

Хүүхэд багачуудад зориулсан үндэсний шинэхэн брэндийг зах зээлд нэвтрүүлж, илүү амтлаг зөөлөн өег “Амтлаг” брэндийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлж чадлаа.

Энэ утгаараа бид МҮХАҮТ-ын ТОП-100 аж ахуй нэгжээр шалгарч, үндэсний манлай үйлдвэр гэдгээ баталж чадсан.



2021 оны үйл ажиллагааны зорилтын хэрэгжилт



Хүүхэд багачуудад чиглэсэн үндэсний бүтээгдэхүүн талх, гурилан төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дунд хомс. Энэ хүрээндээ 2021 оны 8 сараас эхлэн “Амтлаг” брэндийн 6 төрлийн бүтээгдэхүүнийг үйлдэрлэж, худалдаанд гаргасан. Хүүхэд багачууд идэхэд тохиромжтой амттай, бүтээгдэхүүн учраас өглөө, өдрийн цайны үеэр хэрэглэхэд илүү тохиромжтой бүтээгдэхүүн болж чадсан.

ISO22000:2018 стандартын шинэчилсэн хувилбар руу шилжиж баталгаажуулан, хэрэглэгч харилцагчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээнээс хамаарсан санал гомдлыг 5%-иар бууруулж чадлаа



Технологийн түлхүүр ажилтны тогтвор суурьшилыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд дотооддоо зөвлөх инженерүүдээр сургалт явуулан мэргэжлийн чиглэл олгож, сертификат олгов. Түүнчлэн компанийн хэмжээнд COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, ажилчдын дархлааг дэмжих ажлын хүрээнд нийт ажилчдын

- 92.6%- I тун
 - 90.2%- II тун
 - 38.6%- III тун
- хамрагдсан байна.



Бид 2022 онд Талх чихэр ХК-ний бараа бүтээгдэхүүнийг зорилтот зах зээлд тасралтгүй нийлүүлэх, борлуулалт түгээлтийн үйл явцыг илүү сайжруулах, шинэчлэлтийн бодлогын хүрээнд сүлжээ дэлгүүр, хөдөө орон нутгийн борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцагч, ажилчдын сэтгэл ханамжийг урт хугацаандаа хамтарч ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх, техник тоног төхөөрөмжийн дэвшилтийг нэвтрүүлэх, борлуулалтыг тэлэх бодлогыг эрхэм зорилго болгон амжилттай ажиллалаа.





ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЬ СОНГОЛТ
ОНООС

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



What?!



БИЗНЕС ПРОЦЕССИЙН БАРИМТЛАХ СТРАТЕГИ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГИНЖИН
ХОЛБОО УДИРДЛАГЫН СТРАТЕГИ



Үйл ажиллагааны гинжин хэлхээг оновчтой
байдлаар ажлуулахын тулд бүтээгдэхүүн
хөгжүүлэлт, үйлдвэрлэлт, борлуулалт, түгээлт
болон харилцагч нарт хяналт тавих бодлого
баримтлан ажиллах



ХЭРЭГЛЭГЧ БА МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ



ЗАХ ЗЭЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ,
БРЭНДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлээд зарах бус,
дата мэдээлэл, ажиглалт судалгаан дээр
тулгуурлан хэрэглэгчдийн чиг хандлагад
тулгуурлан сэтгэл ханамжийг тэргүүнд
тавин ажиллах



ТАЛХ

НАРИЙН БООВ

БЭЙКЕРИ БҮТЭЭГДЭХҮҮН



ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

Нэвтрэлтийн үе- 100 гаруй нэр төрөл

26% - 39 нэр төрөл

70% - 38 нэр төрөл





Гурван хөлт тулгандаа
Гал голомтоо бадраасан
Өрх тусгаар Идэр залуу гэр бүл
Өв соёлоо уламжлан дээдэлж
Үүрдийн жаргалтай
Өнө мөнхөд хамт байхыг
бэлгэдэв



Залуу гэр бүлүүдэд зориулан “Түмэн насан” брэндийн “Өв соёл” хэвийн боовыг зах зээлд нэвтрүүлэв. Энэхүү бүтээгдэхүүн нь өрх тусгаарлаж, гал голомтоо бадраасан залуу гэр бүлүүдэд зориулагдсан. Мөн “Ковид-19”-ийн үед Монголын үндэсний уламжлалт баяр болох “Цагаан сар”-ын баяраар айл хотлоор зочлохгүйгээр ам бүлээрээ гэр гэртээ өв соёлоо дээдлэн, жижиг ч гэсэн тавгийн идээ засах хэрэгтэй гэсэн соёлыг хэрэглэгчдэд хүргэж чадсан.

МУ-ын хэмжээнд нийт 3,296,866 хүн амын 1/3 нь 25-44 насны хүмүүс байгаа нь Өв соёл хэвийн боовыг өрх тусгаад залуусдаа санал болгож байгаа нь зах зээл хангалттай байгааг харж болно.





Бүтээгдэхүүний нэр төрөл

Дэлгүүрийн байршуулалт



Үзэсгэлэн худалдаа, өдөрлөг



Амтлаг дуу



Реклам

Дүгнэлт



“Амтлаг” брэндийн 6 төрлийн бүтээгдэхүүнийг үйлдэрлэж, худалдаанд гаргасан. Хүүхэд багачууд идэхэд тохиромжтой амттай, бүтээгдэхүүн учраас өглөө, өдрийн цайны үеэр хэрэглэхэд илүү тохиромжтой бүтээгдэхүүн болж чадсан.



**Онцгой
брэнд**

*Бүхэн танд
байгаа*



Багет

*Love French
Baguette*

Хотол

*Аз жаргалын
гэрч*



**Хаан
брэнд**

*Хэзээ ч, хаана ч,
өөрийнхөрөө*



ЗУУН ДАМЖСАН АМТТАН

Баримтат кино

“Талх Чихэр” ХК, Redpoint media студитэй хамтран бялууны түүхийг судалж, Монголчууд 13-р зууны үеэс эхлэн бялуу гэх амттанг хэрэглэж байсан тухай мэдээлэл бүхий баримтат киног хийж, 12 сарын 25-ны өдөр хэрэглэгч, харилцагч нартаа танилцуулсан өдөрлөг зохион байгуулсан. Энэ бол “ХОТОЛ” брэндийг танилцуулах гол арга хэмжээ байсан юм.



ЗУУН ДАМЖСАН АМТТАН

Өдөрлөг

Уг ажлын хүрээнд бид харилцагч, социал нөлөөлөгч, удирдлагын зөвлөл бүхий 90 орчим хүмүүсийг цуглуулж, “Хотол” үйлдвэрээ танилцуулж, “Зуун дамжсан амттан” баримтат киногоо олон нийтэд үзүүлсэн. Уг ажлаараа бид өөрсдийн хамрах хүрээг тэлж, төлөвлөж байсан ажлаа үргэлжлүүлэх том сууриа амжилттай тавьсан хэмээн харж байна.



Зорилт: Хэрэглээг нэмэгдүүлэх, соёлыг түгээх

“Khaan” брэндийг сонгоод цаг заваа хэмнэ. Харин хэмнэсэн цаг заваа гэр бүл, өөртөө зориул! Энэ бол

Аз жаргалын жор



2021 оны хувьд энэхүү төрлийн бүтээгдэхүүний хэрэглэгчид нь харьцангуй залуу байгаа учир брэндээ зөв таниулж цаашид худалдан авахад нь эерэг нөлөө үзүүлэх маркетингийн хоногшуулах ажлуудыг үе шаттайгаар хийсэн болно. “Аз жаргалын жор” идэвхжүүлэлтийн ажил тасралтгүй хүн хөл ихтэй гудамжны лед дэлгэцүүд, автобусны буудлын мэдээллийн самбарууд болон орон сууцны лифтний дэлгэцэнд сурталчилгаагаа 9-р сараас эхлэн 12-р сарыг дуустал өдөр тутмын үйл ажиллагааны хамт цацсан бөгөөд бүтээгдэхүүний борлуулалт ирэх оны 5, 6-р сараас эхлэн ихсэх мөн үнэнч хэрэглэгчид нэмэгдэх төлөвтэй байна.



Талх Чихэр ХК
 Published by Алмаа Алмаа
 3 August 2021

#ТАНИ ӨГЛӨӨ БҮР ТАНТАЙ ХАМТ

33.3K People reached
 75 Reactions, comments and shares
 19.6K 3-second video views
 Retention curve

View More Video Details

Like Comment Share

Up next

- Incredible! Build Amazing Boxing Ring ... Brave Wilderness Life 24 weeks ago · 1.3M views
- Г.Балдурчин үз А-Клерга Мандра SP5 Television 943 22 weeks ago · 2.6M views
- БАЖИГИЙН МАШИНД ХЭН... Unin 25 weeks ago · 1.7M views
- Complacency Blessed Max "Bosses" Holony 18 minutes ago
- 1960's Tonka Hi-way Patrol Car Restoration 763 Restorations 19 weeks ago · 325.3K views



Хэзээ ч, хаана ч өөрийнхөөрөө



Хаан бургерийн талх болон өргөн хэрэглээний талхнуудын савлагааг шинэ жилийн уур амьсгалтайгаар гаргасан.



ТАЛХ ЧИХЭР ЖК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНН СОНГОЛТ
ОНООС

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



What?!




20-45 нас 65.6%



58% Нөхөн
үржихүйн насны

Он/ шилжилт хөдөлгөөн	2018	2019	2020	2021
Орсон	386	473	284	327
Гарсан	298	347	261	287
Нийт	740	847	886	886

ТОГТВОРЖИЛТ



Нээлттэй зар
36/243*8 суваг/



Анкет 5303



Декрет
72/27



Сахилга 56



Шилжсэн 141



Ахмад 243



Групп ХБ 18



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Нийгмийн халамж


Ажилчдаа тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс

- Ажлын байрны ариутгал, хадваргүйжүүлэлтийг тогтмол хийсэн.
- Нийт ажилчдын
 - 92.6%- I тун
 - 90.2%- II тун
 - 38.6%- III тунд хамрагдсан байна.
- Ажлын байрны цомхотгол хийлгүй ажлын байрыг нэмэгдүүлсэн.

Сургалт, хөгжүүлэлт

Ажилчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг дотоод нөөц бололцоогоор тогтмол хийж хэрэгжүүлсэн. Сургалтанд ажилчдаа хамруулж, мэргэжлээ мэргэшүүлэх чиглэлийг тогтмол өгч ажилласан байна.

- Борлуулалтын албаны борлуулагч менежерт ур чадвар олгох сургалт
- Шинэ ажилтаны сургалт
- Үйлдвэрийн ажилчдад стандарттай холбоотой үйлдвэрийн болон эрүүл ахуйн зохистой дадал, технологийн сургалт



Богд уулын ам бүрийг барилгажуулж, хашаа татсан энэ үед үлдсэн ганц ам нь Ширээт болон Арцатын ам бөгөөд төв замаас хамгийн үзэсгэлэнтэй, бөгөөд тод харагддаг онцгой бүс газар юм. Иймээс Үндэсний ууган хүнсний үйлдвэрүүд болох “Талх Чихэр” ХК “Мах Импэкс” ХК, “Милл хаус” ХХК ийн хамт олон “Ногоон хишигтэн” ТББ-тай хамтран Богдхан Уулын Ширээт болон Арцатын ам бүхий 10 га газар 8000 гаруй мод тарьсан.



Аюулгүй ажлын байрыг бий болгохын тулд бид Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулж, үйлдвэр, албад хоорондын хамтын ажиллагааг хэрхэн уялдаа холбоотой байлгах, аюулгүй ажлын байрыг бий болгохын тулд хэрхэн ажиллах тухай уулзалт сургалтыг амжилттай зохион байгуулсан.





ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС



ОЛОЛТ АМЖИЛТ

Монголын үндэсний худалдаа аж
үйлдвэрийн танхимаас шалгаруулдаг
“ТОП-100 АЖ АХУЙ НЭГЖ”-ээр 15
дахь жилдээ шалгарлаа.

“НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-2021”
үзэсгэлэн худалдаанд **“АМТЛАГ”**
брэндийн бүтээгдэхүүнээ онцолж
амжилттай оролцлоо.



2022 ОНЫ ЗОРИЛТ

- 1. Ажиллагсдын хөгжил, ажлын идэвхийг нэмэгдүүлэх менежментийн тогтолцоо бүрдүүлэх, тогтвор сууршилт, үр бүтээлтэй ажиллагсдыг урамшуулах оновчтой, дүгнэхүйц, ил тод системийг бий болгох.**
- 2. Нарийн боовны хөгжлийн дараагийн түвшний амт, сав баглаа боодол бүхий *delice pastry* брэндийг зах зээлд нэвтрүүлэх, бусад бүтээгдэхүүний чанарыг сайжруулахуйц түүхий эдийн судалгаа, хамгамжийг нэмэгдүүлэх.**
- 3. “Хаан”, “багет”, “онцгой” брэнд болон бусад бүтээгдэхүүнүүдийг одоо байгаа зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, амьдарлын мөчлөгийн уртасгахын тулд зах зээлд гүн нэвтрэх.**
- 4. Зах зээлд өөрсдийн өнгө төрх, хэрэглэгчээ олсон “хотол” болон “амтлаг” брэндийн зах зээлийг өргөжүүлж, хөгжүүлэх.**

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

Томоохон амжилт нь урьдчилан төлөвлөж
бодсон олон жижиг зүйлээс бүрддэг.

